Тус байгууллага нь 2021 онд орон нутгийн төсвөөс 385,853.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, нэмэлт санхүүжилтийн дансанд 71,795.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн, мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 457,649.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

#### ***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 83,871.3 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Эд хөрөнгө бүртгэлээс хасах

**Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

тухай” 18 дугаар тогтоолын дагуу 18,531.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд төсвийн хөрөнгөөр 46,052.8 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй орлогоор 7,288.5 мянган төгрөгийн орлогыг бүртгэж, 45,531.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 4,864.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

**Авлага, өглөгийн талаар:**

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,025.0 мянган төгрөгийн авлага, 0.5 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл тайлагнаж, харилцагч бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Санхүү байдлын тайлангаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант хугацааны эцэст бараа материал 88,136.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 882,659.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	3,050.0	1,025.0	(2,025.0)
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	85,191.6	88,136.3	2,944.8
Үндсэн хөрөнгө	870,331.5	882,659.4	12,327.8
Нийт хөрөнгө	958,573.1	971,820.7	13,247.6
Өр төлбөр	-	0.5	0.5
Засгийн газрын оролцоо	958,573.1	971,820.2	13,247.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	958,573.1	971,820.7	13,247.6

Бараа материалын дансны үлдэгдэл 88,136.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 2,944.8 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын нөөц бүрдүүлэлтээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 882,659.4 мянган төгрөг болж 12,327.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 83,871.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 971,820.2 мянган төгрөг болж 13,247.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 367,048.8 мянган төгрөгөөр төлөвлөж, бараа ажил үйлчилгээний зардалд зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 18,805.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 385,853.9 мянган төгрөгөөр сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан байна

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 385,853.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаандаа 357,904.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 27,949.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан 385,853.9 мянган төгрөг нь аймгийн СТСХ-ийн зарцуулах эрхийг Сангийн Яамнаас нээлгэсэн 416,709.5 мянган төгрөгөөс 30,855.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байсанд төлөвлөгөөнд нийцүүлэн залруулга хийсэн болно.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 357,904.0 мянган төгрөг буюу 92,7 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны үлдэгдэл буцаан төвлөрүүлсэн 34,367.2 мянган төгрөг, Засгийн газраас төлсөн усны үнэд 3,912.9 мянган төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар 6,000.0 мянган төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамтарсан багийн санхүүжилт 300.0 мянган төгрөг, Хагас жилийн малын тооны санхүүжилт 775.4 мянган төгрөг, ариутгал, биотехникийн арга хэмжээний зардалд 500.0 мянган төгрөг, Ковид цар тахалтай холбогдуулан үе үеийн төгсөгчдөөс 7,615.0 мянган төгрөг, иргэдээс 3,050.0 мянган төгрөг, УИХ-ын гишүүн Ж.Батжаргалаас 500.0 мянган төгрөгийн хандив, өвс,тэжээлийн орлого 12,273.0 мянган төгрөг, түргэвчилсэн оношлуурын орлого 575.0 мянган төгрөг, лавлагаа, хуудас, бэлчээрийн төлбөрт 1,927.0 мянган төгрөг, нийт 71,795.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас Ковид-19 бэлтгэл бэлэн байдал, түргэвчилсэн оношлуур, халдвар хамгааллын зардалд 11,100.2 мянган төгрөг, худаг уст цэгийн зардалд 3,905.9 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 300.0 мянган төгрөг, хагас жилийн малын тооллогын зардалд 775.4 мянган төгрөг, өвс тэжээл бэлтгэхэд 13,786.8 мянган төгрөг, гамшгаас хамгаалах команд штабын сургалтын зардалд 2,570.0 мянган төгрөг, нохой устгалын зардалд 701.6 мянган төгрөг, Төв аймгийн нийтийн номын санд 750.0 мянган төгрөг, бичиг хэрэгт 40.0 мянган төгрөг, нийт 33,929.9 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаар зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 37,865.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ковид-19-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ эргүүл, жижүүрийн шатахуун, хоол, түргэвчилсэн оношлуурын үнэ, багаж, тоног төхөөрөмж тайлант оны хөрөнгийн зардлаас 16,621.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн данснаас 11,100.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын А/72 дугаар захирамжаар 1,000.0 мянган төгрөгийг эм, эмнэлгийн хэрэгсэлд, мөн А/128 дугаар захирамжаар биотехникийн арга хэмжээ авах ажлын зардалд 500.0 мянган төгрөг ирүүлснийг тус тус зарцуулаагүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Үндсэн хөрөнгө дансанд ОНХС-аар хэрэгжүүлсэн халаалтын шугам 20,300.0 мянган төгрөг, Нацагдоржийн хөшөө талбайн хамт 61,625.6 мянган төгрөг, 1,945.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшлыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 18,531.4 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан.

Бараа материалын дансанд аймгийн ОБГ-аас 1,075.0 мянган төгрөг, Н.Энхболд 1,000.0 мянган төгрөг, Сандаг-очир 1,157.5 мянган төгрөг, Ө.Мягмар 790.0 мянган төгрөг, Багануур дүүргийн онцгой комиссоос 309.0 мянган төгрөг, Монос эмийн сан 627.4 мянган төгрөг, Бэриш Фарм ЭХНТ-аас 765.0 мянган төгрөг, Нарантуул худалдааны төвөөс 234.0 мянган төгрөг, Баярсайхан 200.0 мянган төгрөг гэх мэт 6,765.0 мянган төгрөгийн дархлаа дэмжих болон ариутгал, хамгааллын бүтээгдэхүүн ирүүлснийг үнэ төлбөргүй бүртгэсэн байна.

Тайлант оны хөрөнгийн зардлаас Сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн ТАХ-ийн нэг удаагийн тэтгэмжид 12,626.4 мянган төгрөг, Авто замын барилгын зураг төсөвт 2,000.0 мянган төгрөг, авто замын барилгын зураг төсөвт 2,000.0 мянган төгрөг, Телевизийн бичлэг хийсэн ажлын хөлс 440.0 мянган төгрөг, аймгийн Номын сангаас Нацагдоржийн 110 жилийн ойн түүхэн кино бүтээхэд 750.0 мянган төгрөг, Төв түмний мэнд нэвтрүүлгийн төлбөрт 70.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 43, огт байршуулаагүй 8 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд дараа жилийн төсвийн төсөл, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг хагас, бүтэн жилээр, Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайланг бүтэн жилээр, Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр, Санхүүгийн тайланг хагас жилээр, Худалдан авах ажиллагааны тайлан зэргийг байршуулж, мэдээлээгүй байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлэхдээ сумын нэгдсэн төлөвлөгөө байршуулсан байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг байршуулахдаа 1,2,3,4,11 дүгээр сард орлогын нэг, нэг гүйлгээг байршуулж, 12 дугаар сард орлогын нэг, зарлагын нэг гүйлгээг мэдээлсэн ба шийдвэрийн хуулбарыг байршуулаагүй байна. Байршуулаагүй гүйлгээг хянаж залруулсан.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг байршуулах хэсэгт мэдээллийг бүрэн байршуулаагүй, зөвхөн халаалтын зардлын 23,703.5 мянган төгрөгийг мэдээлсэн ба Өв менежмент ХХК-ний хаягийг бичээгүй байна. Халаалтын зардлаас 12,864.8 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг баримтлан мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, иж бүрэн байршуулж ажиллах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 22-ний өдрийн №06/156 тоот албан бичгээр ирүүлсэн боловч тайлант оны мэдээллээс 43 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг огт байршуулаагүй тул албан шаардлага бичив.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Баяндэлгэр сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна. Акт албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 336,350.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 217,297.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 11,315.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 107,738.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, хөрөнгийн тооллого, тооцоо бодолттой холбоотой зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайлангийн тайлбар тодруулга ирүүлээгүй, Санхүү байдлын тайланд бараа материалын үлдэгдэл 450.0 мянган төгрөгөөр, бусад биет бус хөрөнгө 495.8 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд нийт цэвэр мөнгөн гүйлгээг 66,198.7 мянган төгрөгөөр, санхүү үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны үзүүлэлтүүдийг зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”

гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн хандиваас 77,495.7 мянган төгрөгөөр, бараа материалын дансны үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос 454.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, аймгийн ОБГ-аас ирүүлсэн 1,075.0 мянган төгрөгийн орлогыг бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үндсэн цалин ерөнхий дэвтэр болон ерөнхий журналаас 64,132.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл нийт 1,583.7 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардал 5,411.9 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

#### **4.2 Төлбөрийн акт**

Тус ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүү хяналт аудитын албанаас шалгалт хийж, 2687.8 метр кубээр халаалтын төлбөр тооцох байтал 3353.9 метр кубээр төлсөн зөрчилд төлбөрийн акт бичигдсэн, халаалтын талбайн хэмжээ зөрүүтэй байсан зөрчлийг арилгаагүйгээс 2021 онд 4,292.6 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн

заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн "Мөнгөн шагнал, үр дүнгийн урамшуулал олгох тухай" Б/25 дугаар захирамжаар 3 албан тушаалтанд 1,559.3 мянган төгрөгийн, Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн "Мөнгөн шагнал, үр дүнгийн урамшуулал олгох тухай" Б/23 дугаар захирамжаар 7 албан тушаалтанд 2,938.1 мянган төгрөг, нийт 4,497.4 мянган төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн сангаас олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын 1-д 2101 цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 210104 Урамшуулал гэдэгт ... нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшууллын зардал хамаарахгүй гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын А/72 дугаар захирамжаар 1,000.0 мянган төгрөгийг эм, эмнэлгийн хэрэгсэлд, мөн А/128 дугаар захирамжаар биотехникийн арга хэмжээ авах ажлын зардалд 500.0 мянган төгрөг ирүүлснийг тус тус зарцуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар ажиллагчидтай холбогдсон 1,025.0 мянган төгрөгийн авлага тайлагнагдсан нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн

тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

### 4.3 Албан шаардлага

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагын НӨАТ-ийн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 93,613.4 мянган төгрөгийн гүйлгээ тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 "Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ..." гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд" албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Тайлант онд телевизийн бичлэг хийсэн ажлын хөлсөнд 440.0 мянган төгрөг, аймгийн номын сангаас Нацагдоржийн 110 жилийн ойн түүхэн кино бүтээхэд 750.0 мянган төгрөг, Төв түмний мэнд нэвтрүүлгийн төлбөрт 70.0 мянган төгрөг, нийт 1,260.0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.7-д "хууль тогтоомж, Засгийн газрын албан ёсны шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 43, огт байршуулаагүй 8 мэдээлэл байна. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр,

**Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

хаяг байршуулах хэсэгт мэдээллийг бүрэн байршуулаагүй, зөвхөн халаалтын зардлын 23,703.5 мянган төгрөгийг мэдээлсэн ба Өв менежмент ХХК-ний хаягийг бичээгүй байна. Халаалтын зардлаас 12,864.8 мянган төгрөгийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам", санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй ба өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Хөрөнгийн тооллого, тооцоо бодолттой холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:**

Хөрөнгийн тооллогыг эд хөрөнгийн тооллогын бүртгэл НХМаягт БМ-8-аар бичээгүй тооллогын комиссын бүртгэлийг баталгаажуулан тооцоо бодоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", ТБОНӨТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.4-ийн 1/эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах, 4/ комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх, гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын "оршин байх", "тасалбар болголт", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Эд хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд чанартай, үнэн зөв хийж, тооцоог бодож хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр /

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	ЗДТГ	11	336,350.9	3	217,297.7	4	11,315.0	3	107,738.2	1	0

